

ТАТВАР, ОРЛОГЫН ГАЗРЫН ГУАБ Б.ЭРДЭНЭБАТЫН 2024 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин					
		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
		1	2	3	4	5	6
<b>НЭГ. " ЗОРИЛТ 3: УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ШУДАРГА, ҮР АШИГТАЙ, ҮР ДҮНТЭЙ БҮРДҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>							
1	Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт	Хэрэгжилт, хувиар		Улсын төсөвт өссөн дүнгээр нийт 3297.3 тэрбум төгрөгийн орлого оруулсан байна. - Татварын орлого 3226.2 тэрбум төгрөг, - Хураамжийн орлого 63.7 тэрбум төгрөг, - Өөрийн орлого 7.5 тэрбум төгрөг,	- Гаалийн байгууллагын төсвийн нийт орлого 2024 онд 6727.9 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх үүрэг хүлээсэн. Үүнээс татварын орлогын төлөвлөгөө нь 6582.9 байна. Тайлант хугацаа буюу 05 дугаар сарын 31-ний байдлаар өссөн дүнгээр татварын орлогоор 2563.2 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлэхээс 2455.7 тэрбум төгрөг төвлөрүүлж 95.8 хувийн биелэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 510.8 тэрбум төгрөгөөр буюу 14.1 хувиар өссөн үзүүлттэй байна.  - Гаалийн байгууллага нь ГТХууль, ГЕГ-ын даргын 2013-09-26 өдрийн А/199 дүгээр тушаалыг тус тус үндэслэн 2024 онд улсын төсөвт 130.0 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй. Улсын төсөвт хураамжийн орлогоор 2023 оны эхний 5 сард 50,6 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 59,6 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 117,8 хувийн гүйцэтгэлтэй байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хураамжийн орлого 12,3 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.	2024.01.01 -06.05	95

					- Гаалийн байгууллага 2024 онд улсын төсөвт 15 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй. Үүнээс эхний 5 сард жилд 5,8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 4,6 тэрбум төгрөг төвлөрүүлж 78.7%-ийн биелэлттэй байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хураамжийн орлого 8,4 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.		
2	Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		<ul style="list-style-type: none"> <li>- Улсын төсвийн гаалийн орлогын сар, улирлын хуваарийн тушаалыг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.</li> <li>- Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.</li> </ul>	<p>Нэг. Сангийн сайдын “Төсвийн хуваарь батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 281 дүгээр тушаалыг үндэслэн ГЕГ-ын даргын 2024-02-20-ны А/122 тоот /Хавсралт№3/ “Улсын төсвийн гаалийн орлогын сар, улирлын хуваарь батлах тухай” тушаалыг батлуулан гаалийн газар хороодод хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Харьяа гаалийн газар хороодын улсын төсвийн 2024 оны орлогын сар, улирлын хуваарь,</li> <li>- Улсын төсвийн гаалийн орлогын сарын хуваарь,</li> <li>- Улсын төсвийн хураамжийн орлогын сарын хуваарь,</li> <li>- Улсын төсвийн өөрийн орлогын сарын хуваарь.</li> </ul> <p>Хоёр. Улсын төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээрхи шуурхай хуралдаанд газар хороодод үүрэг даалгавар тухай бүр өгч, тодорхой ажлуудыг гүйцэтгэж ажилласан. Түүнчлэн харьяа гаалийн газар, хороодын сар бүрийн орлогын төлөвлөгөөний дүн шинжилгээг хүлээн авч нэгтгэж удирдлагад танилцуулсан.</p> <p>Гурав. ГЕГ-ын 2024 оны 04 дүгээр сарын 16-ний өдрийн Орлогын төлөвлөгөө биелүүлэх тухай албан бичиг, хавсралтын хамт харьяа гаалийн газар хороодод хүргүүлэн ажилласан.</p>	2024.01.01 -06.05	100
3	Улсын төсвийн гаалийн орлогын төсвийн төслийг хүргүүлэх, мэдээ,	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Улсын төсвийн гаалийн орлогын статистик мэдээг 2023 оны жилийн эцэс, 2024 оны 1, 2, 3, 4, 5	1. Төсвийн орлогыг төвлөрүүлж буй гаалийн болон бусад татварын ногдуулалт, барагдуулалтанд бүртгэлээр хяналт тавьж Кайс, DW, Ераумент-ийг харьцуулан, Сангийн яамны <a href="https://www.mof.gov.mn">https://www.mof.gov.mn</a>	2024.01.01 -06.05	100

	тайлан дүн шинжилгээг сар бүр гаргаж, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон удирдлагад хүргүүлж мэдээллээр хангасан байдал			дугаар саруудын мэдээг сар бүрийн эхний 7 хоногт багтаан гаргаж, төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга, экспортын эрдэс бүтээгдэхүүний мэдээ, эрдэс бүтээгдэхүүн экспортлогч ААН-ийн импортын татварын мэдээг нэгтгэж, УИХ-ын Тамгын газар болон Сангийн яам, удирдлагуудад хүргүүлсэн байна.	сайтнаас Төрийн сангийн дансны хуулгыг өдөр тутам татан авч боловсруулан гүйцэтгэлийн мэдээг 106 удаа гаргаж удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. 2. УИХ-ын Тамгын газар, Сангийн яамны орлогын хэлтэст Улсын төсвийн орлогын дүн шинжилгээ бүхий статистик мэдээг сар бүр хүргүүлэн ажиллалаа. Улсын төсвийн гаалийн орлогын статистик мэдээ 2023 он, 2024 оны 1 сар- 05 сар тус бүрээр боловсруулж хүргүүлсэн. Ингэхдээ төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй танилцуулга, хавсралт статистик мэдээллүүдийг багтаадаг болно. 3. Үндэсний аудитын газар 2023 оны Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийгдэж буйтай Гаалийн байгууллагын 2023 оны төсвийн орлогын гүйцэтгэл, бусад холбогдох мэдээллийг хүргүүлэн ажилласан. 4. Сангийн яамны 2022, 2023 онууд Гаалийн байгууллагад хийгдэж буй аудит холбогдох төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг хүргүүлэн ажилласан.		
4	Улсын төсвийн гаалийн орлогын хагас, бүтэн жилийн тайланг нэгтгэх, хүргүүлэх, хугацаа хэтэрсэн татварын өр авлагыг барагдуулах, буцаан олголт, хойшлуулалт, суутган тооцолт, татварын баталгаа гаргах, түр горимын дансны үлдэгдлийн хяналт зэрэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлт хяналт тавих	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		- Гаалийн байгууллагын татварын орлогын 2023 оны жилийн эцсийн тайланг газар, хороодоос хүлээн авч, нэгтгэж нэгтгэсэн тайланг Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн байна. - Сангийн яамны Төрийн сангийн газарт гаалийн байгууллагын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 5-ны дотор буюу хугацаанд нь 5 удаа гаргаж, цахимаар болон	<b>Орлогын тайланг нэгтгэх:</b> Гаалийн байгууллагын татварын орлогын 2023 оны жилийн эцсийн тайланг газар, хороодоос хүлээн авч, нэгтгэж нэгтгэсэн тайланг Сангийн яамны Төрийн сангийн газарт хугацаанд нь хүргүүлсэн. <b>Татварын хойшлуулалт:</b> 2015 оны 190-р тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс Цагаан суваргын зэс, молибдений баяжуулах үйлдвэр төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Уул уурхайн сайд, "Монголын алт" ХХК, "Эрдэнэс цагаан суврага" ХХК-ны хооронд 2023 оны 05 сарын 09-ны өдөр 41,20,195-2323/0012-5123 тоот гэрээний дагуу Эрдэнэс цагаан суврага ХХК нь	2024.01.01 -06.05	100

			<p>тайлангаар хүргүүлж, тооцоо нийлэн баталгаажуулсан байна.</p> <p>- Хугацаа хэтэрсэн өр авлагыг барагдуулах, буцаан олголт, хойшлуулалт, суутган тооцолт, татварын баталгаа, түр горимын дансны үлдэгдэлд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлт хяналт тавьж ажилласан байна.</p>	<p>гэрээний хавсралт жагсаалтад заагдсан тоног төхөөрөмжийн үнийн дүнд ногдуулсан 22.8 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 37 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс Говь-Алтай аймгийн Тайшир суманд байрлах "Дөрвөлжин шохойн чулууны ордын цемент, шохойн үйлдвэр"-ийн бүтээн байгуулалтад зориулан импортоор оруулж ирсэн техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, "Цэнгазар" ХХК-ийн хооронд 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр 2024/73/47 гэрээний дагуу 2024 оны 3 дугаар сарын 31-нээс эхлэн 3.6 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.</p> <p>Хойшлуулалтын мэдээг сар бүр газар хороодоос авч хяналт тавин ажилласан бөгөөд тайлант хугацаанд татварын хойшлуулалттай холбоотой өр, авлага нэмэгдэж үүсээгүй байна.</p> <p><b>Татварын баталгаа:</b> Тайлант хугацаанд банкны баталгаагаар хийсэн гаалийн бүрдүүлэлт байхгүй байна.</p> <p><b>Өр авлагын барагдуулалт:</b> Тайлант хугацаанд шинээр нэмж үүсгэсэн өр авлага байхгүй байна.</p> <p>Урьд онуудад үүссэн Засгийн газрын шийдвэрээр хойшлуулсан өр авлагыг тодорхой төлөвлөгөө гарган барагдуулж ажиллах талаар чиглэл хүргүүлж хийгдэж байгаа ажлын тайланг сар бүрийн 10-ны дотор гаргуулан авч байна.</p> <p><b>Суутган тооцолт:</b> Газар хороод хоорондын тооцоогоор 690.4 төгрөгийн татварыг шилжүүлэн тооцсон байна.</p> <p><b>Буцаан олголт:</b> Улсын их хурлын 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Гаалийн албан</p>		
--	--	--	---	--	--	--

					<p>татварыг хөнгөлөх тухай хууль, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тогтоолоор батлагдсан гаалийн албан татвараас хөнгөлөх хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийн жагсаалтад хамаарагдах барааг импортолсон 59 аж ахуйн нэгжийн 2023 онд ногдуулсан гаалийн албан татвар болох 2.1 тэрбум төгрөгийн гаалийн албан татварыг буцаан олгох хүсэлтийг хүлээн авч, нягтлан шалгаж Сангийн Яамны төрийн сангийн газарт 3 удаагийн албан бичгээр хүргүүлэн ажилласан.</p> <p>Татварын буцаан олголттой холбоотой ямар нэгэн гомдол гараагүй.</p> <p><b>Түр горим:</b> Түр гормын үлдэгдэл оны эхэнд 62.0 тэрбум төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд 35.4 тэрбум төгрөгийг зарлагдаж 36.6 тэрбум төгрөгийг төрийн сангийн тусгай дансанд нэмж байршуулан тайлант хугацааны эцэст 63.2 төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.</p> <p>Газар хороодоос түр горимын мэдээг сар бүр хүлээн авч нэгтгэн хяналт тавьж ажилласан бөгөөд барьцаа татвартай холбоотой ямар нэгэн өргөдөл, гомдол ирээгүй байна.</p>		
5	Гаалийн болон бусад татвараас чөлөөлөх бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр , хувиар	100%	Гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөн бүрмөсөн болон түр хугацаагаар орох гаалийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, зөвлөмж чиглэлээр хангаж ажилласан байна.	Тайлант хугацаанд татварын чөлөөлөлттэй холбоотойгоор батлагдсан хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх чиглэлийг тухай бүрт албан тоотоор газар, хороодод хүргүүлж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2024.01.01 -06.10	100
					2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02-2/04 тоот албан бичгээр тухайн онд хэрэгжүүлэх татварын чөлөөлөлтийн хууль тогтоомжийн чиглэлийг гаалийн газар, хороодод хүргүүлсэн.		
					2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 180 дугаар тогтоолоор батлагдсан жагсаалтыг үндэслэн мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон		

				<p>улаанбуудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөх чиглэлийг газар, хороодод 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 02-2/1720 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>2024 оны эхний хагас жилд нийт 279.07 сая ам.долларын бараанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу 42.15 тэрбум төгрөгийн гаалийн татвар, 227.3 сая төгрөгийн онцгой албан татвар, 139.11 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг чөлөөлсөн байна. Үүнд:</p> <p>-Гаалийн болон бусад татвараас чөлөөлөх хүсэлтийг edoc.ecustoms.mn цахим хуудсаар ирүүлсэн бичиг 229, хүсэлтийг шийдвэрлэж Гаалийн газар хороодруу явуулсан 108 албан бичиг.</p> <p>-Засгийн газрын зээл, тусламжийн хүрээнд татвараас чөлөөлүүлэх тухай албан хүсэлт тус газарт нийт 601 бүртгэлийн хуудсаар <a href="https://odamis.mof.gov.mn">https://odamis.mof.gov.mn</a> цахим хуудсаар хүлээн авч баталгаажуулан 87.07 сая USD бараанд 14,498.6 сая төгрөгийн гаалийн татвар, 227.6 төгрөгийн онцгой албан татвар, 30,970.7 сая төгрөгийн НӨАТ-ийн татварийн чөлөөлсөн байна.</p> <p>Татвараас чөлөөлөгдөж бүрдүүлэлт хийсэн 7 мэдүүлэгт даатгалын зардлыг мэдүүлэг тус бүрт хуваан хийлгүй бүх зардлыг мэдүүлэг тус бүрт оруулж илүү дүнгээр татварын чөлөөлөлт эдлүүлсэн алдааг залруулж засварлуулсан.</p> <p>Сангийн яамнаас ирүүлсэн 2024 оны 01 дүгээр сарын 29-ний 01/519 албан тоотын дагуу “10 аймгийн төвийн дулааны станц барих” төслийн гүйцэтгэгч Бюксан инженеринг төлөөний газрын импортолсон техникийн шаардлага хангахгүй шугам хоолойн татвараас чөлөөлөгдсөн гаалийн мэдүүлгийг хүчингүй болгож гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг төлүүлэх арга хэмжээг авч ажилллаж байна. Хагас жилд 1,1 сая ам.долларын барааэд 601 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн. 2 албан тоот төлөвлөж тус компанид</p>	
--	--	--	--	---	--

					<p>хүргүүлсэн. 5 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.</p> <p>Тус газарт ирсэн 2022-2023 оны албан бичгийг үдэж хавтаслан архивд 31 боть хүлээлгэн өгсөн.</p> <p>Иргэдийн хэрэглээний боловсролын төвийн шим тэжээл судлаач, Био анагаахын ШУ магистр, сансар марс төсөлийн хоол зүйч Э. Нэмүүзол “Эрүүл зөв хоололт, амьдралын зөв дадал, зуршил, хамт олны дотоод уур амьсгал” сэдвээр Мэдээллийн цаг зохион байгуулсан. 2024.04.05</p> <p>2024-04-09-ны өдрийн 02-2/1343 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд түр горимын хугацаа хэтэрсэн тоног төхөөрөмжийг зохих горимд байршуулах шаардлага хүргүүлсэн.</p>		
6	Гаалийн тариф, гарал үүсэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		<p>- Гаалийн тариф, гарал үүсэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, харьяа гаалийн газар, хороодыг зөвлөмж чиглэлээр хангаж ажилласан байна.</p>	<p>- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн дагуу Гаалийн мэдээллийн CAIS програмын Тарифын санд ЗГ-ын 2024 оны 188-р тогтоолоор батлагдсан Цементийн татварыг 20% байснийг 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл хугацаанд 5% болгон бууруулсан тогтоолыг тарифын санд оруулсан. Эхний хагас жилийн байдлаар нийт 2.3 сая ам.долларын дүн бүхий 36 сая тонн цементийн 1.2 тэрбум төгрөгийг гаалийн татварыг хөнгөлсөн байна.</p> <p>- Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдааны мэдээллийн нэгдсэн цахим санд оруулах Монгол Улсын 2024 онд мөрдөх импортын барааны гаалийн нэн тааламжтай, хөнгөлөлттэй тариф, импортын статистик мэдээллийг ДГБ-аас ирүүлсэн загварын дагуу гарган хүргүүлсэн.</p> <p>- Монгол Японы ЭЗТХ-ээр 2024 оны эхний хагас жилд 117.2 сая ам.долларын бараанд 20.2 тэрбум төгрөгийн, АНДХХ-ийн хүрээнд 6.6 сая ам.долларын бараанд 504 сая төгрөгийн гаалийн татварын хөнгөлөлт үзүүлсэн байна. Эхний хагас жилийн байдлаар хөнгөлөлттэй тарифт хамрагдсан 42 ААН-ийн 2005 гаалийн мэдүүлэг нягтлан шалгаж 2 мэдүүлгийг засварлуулахаар БЦТ-д 2024/80 дотоод зурвас хүргүүлсэн.</p>	2024.01.01 -06.10	100

					- МУ-ын Ерөнхий Сайдын 2023.03.23-ны 55 дугаар захирамж, ЭЗХЯ-ны тушаалаар Монгол улс БНСУ-тай байгуулах ЭЗТХ-ийн 14 дэд ажлын хэсэг байгуулагдаж, Хоёр дахь шатны хэлэлцээ Улаанбаатар хотноо 2024 оны 5 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Тус хэлэлцээнд Барааны тарифын жагсаалт, хориглосон хязгаарласан барааны жагсаалт зэрэг мэдээллийг хүргүүлэн, хэлэлцээрийн төсөлд санал өгч, хэлэлцээний багт ажилласан.		
<b>ЗОРИЛТ 4: ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ</b>							
7	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Гаалийн байгууллагын бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	УИХ-ын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Улсын их хурлын 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тогтоолоор батлагдсан гаалийн албан татвараас хөнгөлөх хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийн жагсаалтад хамаарагдах барааг импортлосон 59 аж ахуйн нэгжийн 2023 онд ногдуулсан гаалийн албан татвар болох 2.1 тэрбум төгрөгийн гаалийн албан татварыг буцаан олгох хүсэлтийг хүлээн авч, нягтлан шалгаж Сангийн Яамны төрийн сангийн газарт 3 удаагийн албан бичгээр хүргүүлэн ажилласан.	2024.01.01 -06.10	100
8	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	1. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулсан байна.	1. Доорх мэдээ тайланг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Үүнд: - Сангийн яаманд 2024 оны 01 дугаар сарын 19-ны өдрийн 02-2/276 тоот албан бичгээр 2023 оны төсвийн зарлагын мэдээг хүргүүлсэн.	2024.01.01 -06.10	100

			<p>2. Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажиллаж, тухай бүр холбогдох мэдээ тайланг дээд шатны байгууллагад хүргэсэн байна.</p>	<p>-Гаалийн болон бусад татварын чөлөөлөлттэй холбоотой хуулийн хэрэгжилтийн биелэлтийг эхний хагас жилийн байдлаар нэгтгэн Сангийн яаманд хүргүүлэх ажлын дагуу ГЕГ-ийн Хуулийн хэлтэст 1 удаа тайлан хүргүүлсэн.</p> <p>-Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн 01/1724 тоот албан бичгийн хүрээнд Засгийн газрын 107 дугаар тогтоолын биелэлтийг сүүлийн 2 жилийн байдлаар хүргүүлсэн.</p> <p>-2024-04-15-17 өдрүүдэд УИХ-с зохион байгуулсан Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцлийг хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголд Гаалийн байгууллагын ажлын хэсэгт орж ажиллаж сонсголд оролцсон. Татварын чөлөөлөлтөөр импортлогдсон сүүлийн 5 жилийн эмийн мэдээг гаргаж оролцсон.</p> <p>-"Ногоон автобусны" нээлттэй сонсголд оролцсон удирдлагуудад татвараас чөлөөлөгдөж орж ирсэн автобусны 2 жилийн мэдээг гаргаж өгсөн. 2024.05.19</p> <p>- Архидан согтууруулахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих санд хөрөнгө төвлөрүүлэх журмын 1.2, 2.2 зүйл заалтын дагуу хэрэгжилтийн тайланг ГЕГ-ийн 2023-05-08-ний 02/1704 албан тоотоор Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>- 2015 оны 190-р тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс Цагаан суваргын зэс, молибдений баяжуулах үйлдвэр төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Уул уурхайн сайд, "Монголын алт" ХХК, "Эрдэнэс цагаан суврага" ХХК-ны хооронд 2023 оны 05 сарын 09-ны өдөр 41,20,195-2323/0012-5123 тоот гэрээний дагуу Эрдэнэс цагаан суврага ХХК нь гэрээний хавсралт жагсаалтад заагдсан тоног төхөөрөмжийн үнийн дүнд ногдуулсан 22.8 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны</p>		
--	--	--	---	--	--	--

				<p>өдрийн 37 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс Говь-Алтай аймгийн Тайшир суманд байрлах “Дөрвөлжин шохойн чулууны ордын цемент, шохойн үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтад зориулан импортоор оруулж ирсэн техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, “Цэнгазар” ХХК-ийн хооронд 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр 2024/73/47 гэрээний гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл Ховд аймгийн Булган дахь гаалийн газарт хүргүүлж 2024 оны 3 дугаар сарын 31-нээс эхлэн 3.6 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.</p> <p>- Сангийн яам, Гаалийн ерөнхий газар болон арилжааны банкуудтай 2021 оны 12 дүгээр сарын 27-ний өдөр байгуулсан Тэг үлдэгдэлтэй дансны 2023 оны хэрэгжилтийг гэрээний заалт тус бүрээр дүгнэж Төрийн сангийн газарт хүргүүлсэн.</p> <p>-Шилэн дансны мэдээллийг <a href="https://info.shilendans.gov.mn">https://info.shilendans.gov.mn</a> хуудсанд 05 удаа хугацаандаа “Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт”-ийн талаар мэдээллэж ажилласан.</p>		
--	--	--	--	---	--	--

**Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх**

9	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Нэгжийн эрсдэлийг таньж тогтоон ангилсан байна.	<p>1. Улсын төсвийн орлого бүрдүүлэх, статистик мэдээ боловсруулах, дүн шинжилгээ хийх ажлаар эрсдэл тооцон ангилсан. Энэ чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэв.</p> <ul style="list-style-type: none"> <li>- УБТЗ-ын Тьюнжин боомт дахь ачаа бөөгнөрөл, хэрхэн татах талаар мэдээллийг тухай бүр Сангийн яаманд хүргүүлэн ажилласан.</li> <li>- Улсын төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр ажлын хэсэгт орж ажиллаж байна.</li> </ul>	2024.01.01 -06.10	100
---	--	-------------------------	--	---	--	-------------------	-----

					<p>- МУИС Гаалийн байгууллагын хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Улсын төсвийн орлогыг таамаглах төсөл хийгдэж байна.</p> <p>1. Бүрдүүлэлтийн цахим төвд Засгийн газрын 107 дугаар тогтоолд хамаарахгүй барааг оруулсан эсэхийг нягтлан шалгаж алдааг засварлуулахаар 2024/12 дугаартай дотоод зурвасыг хүргүүлж ажилласан.</p> <p>2. Татварын чөлөөлөлтөөр хийгдсэн бүрдүүлэлтийн хамгийн их алдаа гардаг эрсдэл өндөртэй горимын код, хэлцлийн код, чөлөөлөлтийн кодыг 401, 402, 403 горимын хүрээнд нягтлан шалгаж 25 алдааг илрүүлж мэдүүлгийг засварлуулж ажилласан.</p> <p>3. Гарал үүслийн чиглэлээр эрсдэл тооцож, эхний хагас жилийн байдлаар хөнгөлөлттэй тарифт хамрагдсан 42 ААН-ийн 2005 гаалийн мэдүүлэг нягтлан шалгаж 2 мэдүүлгийг засварлуулахаар БЦТ-д 2024/80 дотоод зурвас хүргүүлсэн.</p> <p>4. Засгийн газрын шийдвэрээр гурвалсан гэрээ байгуулан 2 жилийн хугацаагаар хойшлуулсан татварын эргэн төлөлт Сангийн яамтай шүүхийн шатанд хэлэлцэгдэж байгаа гэсэн шалтгаанаар хугацаандаа төлөгдөхгүй байдаг эрсдэл үүсч болзошгүй байгааг олж тогтоож гурвалсан гэрээнд эргэн төлөлтийг тодорхой график гарган гэрээний хугацааны эцэст буюу 2 жилийн хугацаанд тэнцүү хуваан төлж дуусгахаар заасан заалт оруулах саналыг Сангийн яамны мэргэжилтэнд хүргүүлэн тусгуулсан.</p>		
10	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, Мэргэжлийн зөвлөл, Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд биелүүлж ажилласан байна.	<p>1. Удирдлагын шуурхай хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Захиргааны зөвлөлийн хуралдаан, Онлайн хурлаас ТОГ-т өгсөн нийт 5 үүрэг даалгавар, 2 зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллахад оролцов.</p> <p>2. Сангийн яамны АУДИТ-д татварын чөлөөлөлтийн мэдээг сүүлийн 2 жилээр гаргаж танилцуулсан.</p>	2024.01.01 -06.10	100

					<p>3. СЯ-ны шуурхай хуралдаанд 7 хоног бүрийн пүрэв гаригт хүлээгдэж буй гүйцэтгэл, орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар харьяа гаалийн газар хороодоос нэгтгэн, дүн шинжилгээ танилцуулга бэлтгэн тухай бүр хүргүүлэн ажиллалаа.</p> <p>4. Гаалийн ерөнхий газрын дэд даргын баталсан "Гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавих, гарал үүслийн чиглэлээр чадавхыг бэхжүүлэх ажлын төлөвлөгөө"-ний хүрээнд газар хороодод хөнгөлөлттэй гарал үүслийн гэрчилгээтэй бараанд хяналт тавьж ажилласан.</p>		
11	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Ажлын цаг ашиглалтын 2023 оны үнэлгээг өмнөх оны эхний хагас жилийнхээс бууруулахгүй ажиллана.	2024 онд ажиллавал зохих 109 өдөр, 872 цаг ажиллахаас 109 өдөр, 872 цаг ажилласан байна. Өвчтэй,чөлөөтэй болон тасалсан цаг байхгүй.	2024.01.01 -06.10	100
12	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Гадаад орны Засгийн газар, банк санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн хүрээнд нийлүүлсэн бараа, буцалтгүй тусламжийн хүрээнд татвараас чөлөөлүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй аж ахуйн нэгж байгууллагуудад зориулсан сургалт зохион байгуулсан байна.	<p>1. МХАҮТ-ын Даргын 2024 оны 3 дугаар сарын 31-ний А/31 тоот ТОП-100 аж ахуйн нэгж эрэмбэлэх ажлын хэсэгт ажилласан.үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- МҮХАҮТ-д 2023 оны байдлаар Улсын төсөвт төвлөрүүлсэн гаалийн албан татвар, импортын НӨАТ, АБДТАТ, онцгой албан татваруудын орлогыг ААНБ-уудаар эрэмбэлж эхний 500 ААНБ-ын мэдээллийг /policy@mongolchamber.mn/ цахим хаягаар ,</li> <li>- МҮХАҮТ-д 2024.05.15-нд болсон МУ-ын ТОП-100 ААНБ эрэмбэлэх ажлын хэсгийн эхний шатны эрэмбэлэх ажлын уулзалтанд оролцсон.</li> </ul> <p>2. ГЕГ-ын 2024 оны 06 дугаар сарын 06-ны А/339 тоот Ажлын хэсэг байгуулах тухай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.</p> <p>3. Сургалтын төвийн хүсэлтээр 80 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт "Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа, ажил, үйлчилгээг гаалийн болон нэмэгдсэн өртгийн</p>	2024.01.01 -06.10	100

					албан татвараас чөлөөлөх нь” сэдвээр 1.30 цагийн сургалтыг 2 удаа явуулсан. 4. ДГБ, Японы гаалийн хамтын ажиллагааны санхүүжилттэй Монгол улсын гарал үүслийн чадавхыг бэхжүүлэх сургалтыг Монгол улсад анх удаа зохион байгуулж, ГЕГ, харьяа гаалийн газар хороодын 30 албан хаагчийг хамруулсан.		
<b>Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ</b>							
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Сургалтад хамрагдсан байна.	Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 аргазүйн цахим сургалтад 7 удаа хамрагдсан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан УИХ-ын сонгуулийн тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь сэдэвт цахим сургалтанд хамрагдсан.	2024.01.01-06.10	100
2	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Сургалтанд хамрагдсан байна.	Сургалтын төвөөс зохион байгуулж буй ГЕГ-ын албан хаагчдыг хамруулсан англи хэлний сургалтанд долоо хоногт 2 удаа хамрагдаж англи хэлний мэдлэгээ дээшлүүлж байна.	2024.01.01-06.10	100
3	ДГБ болон ДХБ аас боловсруулан гаргасан “Барааны гарал үүслийн чиглэл”-ээр гарсан олон улсын хууль тогтоомжийг судлах, ДГБ аас зохион байгуулах сургалтад хамрагдан мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Сургалтанд хамрагдсан байна.	ДГБ болон ДХБ-аас 2024 оны 3 дугаар сарын 25-39-ний өдрүүдэд Гаалийн ерөнхий газарт зохион байгуулсан “Гарал үүслийн үндэсний семинар”-т хамрагдсан	2024.01.01-06.10	100

ТАЙЛАНГИЙН БИЕЛЭЛТ ОРУУЛСАН:

ТАТВАР, ОРЛОГЫН ГАЗРЫН ГУАБ  Б.ЭРДЭНЭБАТ/

Огноо: 2024.06.10

ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

БҮРГЭДЭЭГИЙН ЭРДЭНЭБАТЫН

2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,  
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС  
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Нэгжийн нэр: ТАТВАР, ОРЛОГЫН ГАЗАР

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
<b>ЗОРИЛТ 3: УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ШУДАРГА, ҮР АШИГТАЙ, ҮР ДҮНТЭЙ БҮРДҮҮЛЭХ-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт</b>					
1.	Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт	57	10	67	
2.	Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ	58	10	68	
3.	Улсын төсвийн гаалийн орлогын төсвийн төслийг хүргүүлэх, мэдээ, тайлан дүн шинжилгээг сар бүр гаргаж, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон удирдлагад хүргүүлж мэдээллээр хангасан байдал	60	10	70	
4.	Улсын төсвийн гаалийн орлогын хагас, бүтэн жилийн тайланг нэгтгэх, хүргүүлэх, хугацаа хэтэрсэн татварын өр авлагыг барагдуулах, буцаан олголт, хойшлуулалт, суутган	58	9	67	

	тооцолт, татварын баталгаа гаргах, түр горимын дансны үлдэгдлийн хяналт зэрэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих				
5.	Гаалийн болон бусад татвараас чөлөөлөх бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт	60	10	70	
6.	Гаалийн тариф, гарал үүсэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийн хэрэгжилт	60	10	70	
7.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	58	10	68	
8.	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт / Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажиллаж, тухай бүр холбогдох мэдээ тайланг дээд шатны байгууллагад хүргэсэн байна. Хуулийн төсөлд санал өгөх/	55	10	65	
<b>Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх</b>					
1.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	57	10	67	
2.	Үүрэг даалгаврын биелэлт	57	10	67	
3.	Ажлын цаг ашиглалт	58	9	66	
4.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	55	8	63	
<b>Дундаж оноо:</b>				67.3	
<b>Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ</b>					
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо	
	1	2	3	4	
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	86.6	13		

2	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх	86.6	13	
3	ДГБ болон ДХБ аас боловсруулан гаргасан "Барааны гарал үүслийн чиглэл"-ээр гарсан олон улсын хууль тогтоомжийг судлах, ДГБ аас зохион байгуулах сургалтад хамрагдан мэдлэгээ дээшлүүлэх	100	15	
<b>Дундаж оноо:</b>			<b>13.6</b>	

### 3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Асуудал шийдвэрлэх	6	
3.	Хариуцлагатай байдал	7	
4.	Дүн шинжилгээ хийх	6	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар 1.	7	
<b>Дундаж оноо:</b>		<b>6.6</b>	

### 4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	7
2.	Багаар ажиллах	7
3.	Харилцаа	7
<b>Дундаж оноо:</b>		<b>7</b>

### 5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	67.3
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13.6
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.6

4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
<b>Нийт оноо =</b> (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ) )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		<b>94.5</b>

**Үнэлгээ өгсөн:**

**Нэгжийн дарга**

Татвар, орлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



/С.Баярмаа/

2024.06.10

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:**

**Төрийн жинхэнэ албан хаагч:**

Гаалийн улсын ахлах байцаагч



/Б.Эрдэнэбат/

2024.06.10

**Үнэлгээг хянасан :**

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



/Г.Энхтайван/

2024.06.10

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



/Ж.Баясгалан/

**Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч**

Дарга



/Р.Отгонжаргал/